



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/93

Ховд

Хүүхдийн тоглоомын талбай /Жаргалант сум, Бугат баг/-н
ажилд дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Инжэд төр” ХХК-ийн хийж гүйцэтгэж буй Хүүхдийн тоглоомын талбай /Жаргалант сум, Бугат баг/-н ажилд ажлын тоо хэмжээнд тусгагдаагүй нэмэлтээр хийгдсэн хүүхдийн тоглоомын талбайд сагсны талбай байгуулах ажлыг нягтлан шалгаж гэрээ байгуулан төсвийн зөрүү, үлдэгдэл санхүүжилтийг шийдвэрлэх боломжтой эсэх талаар шийдвэр гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Туулайтулга	- Жаргалант сумын Засаг даргын орлогч
Гишүүд: Н.Ганзориг	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
Г.Цэдэнбал	- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч
Б.Түмэндэлгэр	- Бугат багийн Засаг дарга
Х.Дэмид	- Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн
З.Бурмаа	- “Инжэд төр” ХХК-ийн захирал
Нарийн бичгийн дарга: Б.Жамбалдорж	- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн

2. Тус ажлыг шийдвэрлэх боломжтой эсэх талаар ажлын хэсгийн дүгнэлтийг гаргаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Туулайтулга/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ

Т.ЖАРГАЛСАЙХАН

0400 01 0505
Zah A/93 Kh